ХАРИЛЦАГЧИД ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЕРӨНХИЙ ГЭРЭЭ
(БАЙГУУЛЛАГА)

_____ _____ _____

Энэхүү "Харилцагчид үйлчилгээ үзүүлэх ерөнхий гэрээ" (цаашид "**Гэрээ**" гэх)-г Монгол Улсын Иргэний хуулийн 445-450 дугаар зүйл, Банкны тухай хуулийн 11 дүгээр зүйл, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 3 дугаар бүлгийг тус тус үндэслэн,

Нэг талаас Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 1-р хороо, 14210, Энхтайваны өргөн чөлөө 19 / 🅱 бахдал.эрдэнэс.мэдрэгч хаягт орших Худалдаа, хөгжлийн банк (цаашид "**Банк**" гэх)-ны ---------салбар,

Нөгөө талаас _____ хаягт орших _____ (Регистрийн дугаар _____) (цаашид "**Харилцагч**", хамтад нь "**Талууд**" гэх) нар дараах нөхцөлүүдийн талаар харилцан тохиролцож байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гэрээний зорилго нь Банк Харилцагчид Гэрээний 2.2 дахь хэсэгт заасан Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг Гэрээнд заасан нөхцөлөөр үзүүлэх, үзүүлсэн үйлчилгээнийхээ шимтгэлийг Харилцагчаар төлүүлэхтэй холбоотой Талуудын хооронд үүсэх харилцаа, Талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг зохицуулахад оршино.

1.2. Гэрээнд ашигласан дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

1.2.1. "**Банкны нэгж**" гэж Банкны салбар, төлөөлөгчийн газар, тооцооны төв, тооцооны касс зэрэг хуулийн этгээдийн эрхгүй байгуллагыг;

1.2.2. "**Банкны үйлчилгээний хүү, шимтгэлийн ерөнхий нөхцөл**" (цаашид "**ХШЕН**" гэх) гэж Банкнаас үзүүлэх бүтээгдэхүүн, үйлчилгээний хөлсийг тусгасан баримт бичгийг;

1.2.3. "**Бүтээгдэхүүн, үйлчилгээний ерөнхий нөхцөл**" (цаашид "**БҮЕН**" гэх) гэж Банкнаас энэхүү Гэрээний дагуу үзүүлэх бүтээгдэхүүн, үйлчилгээний нөхцөл, түүнтэй холбоотой Талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тусгасан Гэрээний Хавсралт №1-т заасан баримт бичгийг;

1.2.4. "**Давхар татварын хэлэлцээр**" гэж Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон бусад Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг;

1.2.5. "**Алдаатай гүйлгээ**" гэж математик тооцоолол, нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэглээний алдаа, баримтыг буруу ойлгох, залилан болон хяналтгүйгээр хийсэн гүйлгээ болон банкны программын, эсхүл үйл ажиллагааны алдаанаас үүдэн алдаатай хийгдсэн гүйлгээг;

1.2.6. "**Сэжигтэй гүйлгээ**" гэж мөнгөний гарал үүсэл тодорхойгүй гүйлгээ, эцсийн хүлээн авагч нь тодорхойгүй гүйлгээ, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх санхүүгийн хяналтын механизм бүрдүүлээгүй улсаар дамжуулан хийсэн гүйлгээ болон Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэж үзэж байгаа гүйлгээг тус тус ойлгоно.

1.3. Гэрээнд тодорхойлогдоогүй ашигласан бусад нэр томьёог Монгол Улсын хууль тогтоомжид заасан утгаар ойлгоно.

Хоёр. Бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэх үндсэн нөхцөл

2.1. Харилцагч Банктай дараах мэдээлэл, үйлчилгээ авах сувгуудаар дамжуулан харилцана. Үүнд:

2.1.1. Харилцагчийг хариуцсан Банкны нэгжийн хамтын ажиллагааны менежер болон захирлууд;

2.1.2. Банкны Контакт төвийн утасны дугаар (18001977, 70161988, 19001977);

2.1.3. Банкны Контакт төвийн цахим шуудангийн хаяг (info@tdbm.mn);

2.1.4. Банкны www.tdbm.mn цахим хуудас;

2.1.5. Банкны чат программ болон олон нийтийн сүлжээний чат;

2.1.6. Харилцагчтай зайнаас холбогдох боломж бүхий Банкны бусад сувгууд.

2.2. Банк нь Харилцагчийн гаргасан хүсэлт, түүний бүрдүүлж өгсөн хуулийн шаардлага хангасан бичиг баримтыг үндэслэн дараах Бүтээгдэхүүн, үйлчилгээг Гэрээ болон БҮЕН-ийн дагуу үзүүлнэ. Үүнд:

2.2.1 "**Төлбөр тооцооны үйлчилгээ**" буюу Харилцагчийг төлөөлөх этгээдийн гарын үсгийн маяг, тамга, тэмдгээр баталгаажсан харилцах данс (цаашид "**Данс**" гэх) нээж, төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэх;

2.2.2. "**Түр дансны үйлчилгээ**" буюу Банканд хуулийн этгээдийг төлөөлж буй этгээдээс бичгээр гаргасан данс нээлгэх хүсэлт, хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалтын хуудсыг үндэслэн нээгдсэн зарлагын гүйлгээ хийх эрхгүй харилцах дансыг нээж, үйлчилгээ үзүүлэх;

2.2.3. "**Байгууллагын дебит картын үйлчилгээ**" буюу Харилцагчийн төлбөр тооцоонд ашиглах төлбөрийн картыг Харилцагчийн зөвшөөрөгдсөн ажилтанд олгож, Картаар төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэх;

2.2.4. "**Ти Ди Би Онлайн үйлчилгээ**" буюу Харилцагчийн хүсэлтийн дагуу тус үйлчилгээний эрхийг нээж, интернет холболт бүхий төхөөрөмж (гар утас, компьютер, таблет гэх мэт)-өөр дамжуулан Банкны үйлчилгээг Ти Ди Би Онлайн үйлчилгээний цахим хуудас болон гар утасны хувилбараар зайнаас үзүүлэх;

2.2.5. "**Банкны дансаар ажилтнуудын цалин олгох үйлчилгээ**" буюу Харилцагчийн нэр дээр данс нээж, тухайн дансаар Харилцагчийн ажилтнуудын цалинг тогтсон өдөр олгох үйлчилгээ үзүүлэх;

2.2.6. "**Автомат билл төлбөрийн үйлчилгээ**" буюу Харилцагчийн хүсэлтийн дагуу тус үйлчилгээнд бүртгэснээр, нэхэмжлэгч байгууллагаас ирүүлсэн нэхэмжлэхийг үндэслэн Харилцагчийн дансаас төлбөрийг шилжүүлэх үйлчилгээ үзүүлэх;

2.2.7. **"Мэдэгдлийн үйлчилгээ"** буюу Харилцагчийн Банканд бүртгэлтэй цахим шуудангийн хаяг болон гар утасны дугаараар Харилцагчийг бүртгэсний үндсэн дээр түүний Банкан дахь дансны гүйлгээ, үлдэгдлийн мэдээлэл болон бусад төрлийн лавлагааны талаар мэдэгдэл илгээх үйлчилгээ үзүүлэх;

2.2.8. "**Төвлөрүүлэх шилжүүлэг үйлчилгээ**" буюу Дансны үлдэгдлийг тогтмол нэг дүнгээс их, бага, эсхүл тэнцүү байлгаж, нэг данс дахь үлдэгдлийг нөгөө данс руу нь тогтмол давтамжтайгаар автоматаар шилжүүлэх үйлчилгээ үзүүлэх.

2.3. Харилцагч нь Гэрээний 2.2 дахь хэсэгт заасан Бүтээгдэхүүн, үйлчилгээ тус бүрийг авах хүсэлтээ Банканд гаргасан өдрөөс эхлэн тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой Гэрээ болон БҮЕН-ийн зохицуулалт Талуудын хувьд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх ба тухайн хүсэлт нь Гэрээний хавсралт болно.

2.4. Харилцагч Гэрээний 2.2 дахь хэсэгт заасан Бүтээгдэхүүн, үйлчилгээг Банкнаас үзүүлж буй цахим суваг болон төлбөрийн картыг ашиглан авсан нь Харилцагч Банканд өөрийн биеэр ирж, төлбөр тооцооны баримтаар гүйлгээ хийлгэж, үйлчлүүлсэнтэй адил тооцогдож, хүчин төгөлдөр байна.

2.5. **Зөвшөөрөл олгох тухай:** Харилцагч нь Гэрээг Банктай байгуулснаар, Зээлийн мэдээллийн сан болон Цахим мэдээллийн санд байршсан Харилцагчийн мэдээллийг харах, хувилан авах эрхийг Банканд олгож, зөвшөөрсөн болно. Энэхүү зөвшөөрлийг Банкны тухай хуульд заасан Харилцагчийн бичгээр олгосон зөвшөөрөл гэж үзнэ.

2.6. **Зөвшөөрөл олгох тухай:** Харилцагчийн хувьцаа эзэмшигч нь Америкийн Нэгдсэн Улсын харьяат иргэн бол Банкны тусгай маягтын дагуу өөрийн болон дансны мэдээлэл, TIN/SSN/EIN дугаарыг АНУ-ын Internal Revenue Service (IRS)-д мэдээлэхийг Банканд үүгээр зөвшөөрч байна.

2.7. Гэрээний Хавсралт 1 болох БҮЕН болон ХШЕН нь Гэрээний салшгүй нэг хэсэг болно.

Гурав. Талуудын нийтлэг эрх, үүрэг

3.1. Банк дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

3.1.1. Харилцагчийн төлбөр тооцооны баримтыг шалгасны үндсэн дээр дансны боломжит үлдэгдэлд багтаан хүлээн авсан дараалын дагуу тухайн өдөрт багтаан санхүүгийн гүйлгээг гүйцэтгэх;

3.1.2. Харилцагчийн дансны дугаар, гүйлгээний талаарх мэдээлэл, дансны үлдэгдэл болон зээл, бизнесийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийн нууцлалыг чанд хадгалж, Харилцагч бичгээр зөвшөөрсөн, эсхүл хуульд зааснаас бусад тохиолдолд бусдад гаргаж өгөхгүй байх;

3.1.3. Харилцагчийн дансны үлдэгдэлд хүү төлөхөөр ХШЕН-д заасан тохиолдолд уг үлдэгдэлд оногдох хүүг төлөх;

3.1.4. Шүүх, прокурор, цагдаа, татварын байгууллага зэрэг төрийн эрх бүхий байгууллагын шаардлага, хууль болон гэрээнд заасан үл маргах журмаар төлөх төлбөрөөс бусад тохиолдолд Харилцагчийн зөвшөөрөлгүйгээр данснаас зарлагын гүйлгээ хийхгүй байх;

3.1.5 Харилцагчийн дансны хуулга, дансны үлдэгдэл, Банкны тодорхойлолт зэрэг мэдээллийг Харилцагчийн хүсэлтийн дагуу гаргаж өгөх;

3.1.6. Харилцагчийн Банкаар төлбөр тооцоогоо гүйцэтгүүлэх хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй байх;

3.1.7. Хууль болон Гэрээгээр хүлээсэн бусад үүргийг биелүүлэх;

3.2. Банк дараах эрх эдэлнэ. Үүнд:

3.2.1. БҮЕН болон ХШЕН-д өөрийн санаачилгаар нэмэлт, өөрчлөлт оруулах;

3.2.2. Харилцагчаас бүрдүүлсэн баримт бичиг нь Гэрээний 2.2 дахь хэсэгт заасан Бүтээгдэхүүн, үйлчилгээг авахад шаардлага хангаагүй тохиолдолд тухайн үйлчилгээг үзүүлэхээс татгалзах;

3.2.3. Гэрээний дагуу үзүүлсэн Бүтээгдэхүүн, үйлчилгээний шимтгэлийг ХШЕН-д заасны дагуу Харилцагчийн данснаас үл маргах журмаар суутган авах эрхтэй бөгөөд Гэрээ дуусгавар болгосон тохиолдолд тухайн шимтгэлийг нөхөж олгохгүй байх;

3.2.4. Гадаад валютын харилцах данс нь харилцагч гадаад шилжүүлэг, төлбөр тооцоо гүйцэтгэх, гадаадаас валютаар төлбөр, шилжүүлэг хүлээн авах зориулалттай бөгөөд Банк харилцагчийн төлбөр тооцоог түүний дансны үлдэгдэлд багтаан бэлэн бусаар саадгүй гүйцэтгэх ба харилцах дансанд бэлэн валют тушаах, бэлэн валют авах, түүнтэй холбогдуулан үүсэх харилцаанд Банк хязгаарлалт хийх;

3.2.5. Гэрээний 3.2.3 дахь заалтын дагуу Харилцагчийн шимтгэл төлөх Дансны үлдэгдэл хүрэлцэхгүй байгаа тохиолдолд түүний данснаас суутган авах;

3.2.6. Банк хууль эрх зүйн зохицуулалтын өөрчлөлт болон зохицуулагч байгууллагын бодлого, чиглэл, зах зээлийн нөхцөл байдлаас хамааран бүх төрлийн валютын гүйлгээг ямар ч хэлбэрээр (хэмжээ, арилжааны төрлөөр гэх мэт) хязгаарлах;

3.2.7. Харилцагчийн бүх төрлийн дансны үлдэгдэл шимтгэл төлөхөд хүрэлцэхгүй буюу боломжгүй байгаа тохиолдолд Харилцагчид үйлчилгээ үзүүлэхээс татгалзах;

3.2.8. Харилцагч Гэрээ, БҮЕН болон бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэх заавар, зөвлөмжийг зөрчсөн тохиолдолд Банк дараах үйлдлийг хийх эрхтэй. Үүнд:

3.2.8.а. Харилцагчийн гүйлгээ хийх эрхийг түдгэлзүүлж, Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, зөрчлийг арилгах арга хэмжээ авахыг шаардах;

3.2.8.б. Харилцагчийн хийх гүйлгээ болон гүйлгээний дүнд тодорхой хязгаарлалтуудыг тогтоох;

3.2.8.в. Харилцагч нь Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол Гэрээг нэг талын санаачилгаар цуцалж, бүтээгдэхүүн, үйлчилгээний эрхийг цуцлах;

3.2.8.г. Харилцагчийн буруугаас Банк болон аливаа этгээдэд хохирол учирсан бол Харилцагчийн Банкан дахь данснаас хохирлыг үл маргах журмаар суутган авах, дансны үлдэгдэл нь хохирлыг бүрэн барагдуулж хүрэхгүй тохиолдолд хуульд заасны дагуу бусад арга хэмжээг авах;

3.2.8.д. Дансны үлдэгдлээ санаатай болон санамсаргүй улайлган (өр болгох буюу дансны боломжит үлдэгдлээс хэтрүүлэх) ашигласан тохиолдолд төлж барагдуулахыг шаардах, бусад данснаас суутган авах, Монголбанкны зээлийн мэдээллийн санд бүртгүүлэх, тухайн улайлтыг төлүүлэх талаар хуульд заасны дагуу бусад арга хэмжээг авах.

3.2.9. Харилцагчийн буруугаас хийгдсэн алдаатай гүйлгээ бусад Харилцагчийн дансанд шилжсэн тохиолдолд залруулах үүрэг хүлээхгүй байх;

3.2.10. Харилцагчийн хийсэн төлбөр тооцооны үнэн зөв эсэхэд эргэлзсэн, хүлээн зөвшөөрөхгүй байгаа, эсхүл алдаатай, илүү, дутуу болон давхар хийсэн аливаа маргаантай гүйлгээг (цаашид "Маргаантай гүйлгээ" гэх)-г шийдвэрлэхийн тулд холбогдох мэдээллийг шалгах, маргаантай гүйлгээний дүнгээр дансанд түр хаалт тавих;

3.2.11. Маргаантай гүйлгээнд Харилцагчийн буруутай үйлдэл нотлогдвол түүний данснаас хохирол, зардлыг үл маргах журмаар суутган авах;

3.2.12. Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу харилцагчийн дансанд БҮЕН болон ХШЕН-ийн дагуу олгодох хүүгийн орлого, түүнтэй адилтгах бусад орлогод ногдуулах албан татварыг суутгаж, холбогдох татварын байгууллагад шилжүүлэх;

3.2.13. Хууль болон Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэхийг харилцагчаас шаардах;

3.2.14. Гэрээний 1.2.5 дахь заалтад заасан Алдаатай гүйлгээ хийгдсэн тохиолдолд Банк нь харилцагчийн харилцах болон хугацаагүй хадгаламжийн данснаас үл маргах журмаар суутган авч, алдаатай гүйлгээг залруулах;

3.2.15. Банк, харилцагчийн аливаа гүйлгээ, үйлдлийг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх санхүүгийн гэмт хэрэгтэй холбоотой байж болзошгүй гэж үзсэн тохиолдолд Харилцагчаас гүйлгээ, үйлдэлтэй холбоотой тодруулга авах;

3.2.16. Банк, харилцагчийн аливаа гүйлгээ, үйлдлийг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх санхүүгийн гэмт хэрэгтэй холбоотой байж болзошгүй гэж үзсэн тохиолдолд, эргэлзээг гаргах хүртэл харилцагчийн гүйлгээг царцааж, тодруулга авах;

3.2.17. Банк, Монгол Улсын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу, харилцагч болон түүний гүйлгээг таньж мэдэх ажиллагааны хүрээнд Банкнаас шаардсан мэдээлэл, баримтыг өгөхөөс татгалзсан харилцагчид үйлчилгээ үзүүлэхгүй байна;

3.2.18. Харилцагч холбогдох мэдээлэл, баримтыг өгсөн хэдий ч Харилцагчийн бизнесийн зорилго тодорхойгүй, Харилцагчийн үйл ажиллагаатай нийцээгүй, Харилцагчийн үйлдэл болон гүйлгээ эдийн засгийн илт үндэслэлгүй гэж үзвэл Харилцагчид үйлчилгээ үзүүлэхээс татгалзана;

3.2.19. Шаардлагатай тохиолдолд харилцагчийн гүйлгээ, үйлдлийг нарийвчлан таньж мэдэж, судалгаа хийж харилцагчийн эрсдэлийн түвшинг "хэт өндөр" гэж үнэлсэн тохиолдолд, комплайнсын эрсдэлийн дүгнэлт эсвэл гүйцэтгэх удирдлагад танилцуулж, харилцагчид үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, хязгаарлах.

3.2.20. Банкнаас бүхлээр нь тохируулсан хяналтын дүрмээр харилцагчийн Ти Ди Би Онлайнаар хийсэн гүйлгээ нөхцөл таарч онлайн банкаар хийх боломжгүй байх тохиолдолд Банк хариуцлага хүлээхгүй ба харилцагч салбарт ирж гүйлгээг гүйцэтгэнэ.

3.2.21. Хууль болон Гэрээнд заасан бусад эрх.

3.3. Харилцагч дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

3.3.1. Банкны www.tdbm.mn цахим хуудсанд нэвтэрч, БҮЕН болон ХШЕН-д оруулсан нэмэлт, өөрчлөлттэй танилцах;

3.3.2. Банкнаас тогтоосон шимтгэл, хураамжийг ХШЕН-д заасны дагуу төлөх;

3.3.3. Дансны гүйлгээ, үлдэгдлийг Банкны хуулгатай тохируулан шалгаж зөрүүтэй тохиолдолд Банканд яаралтай мэдэгдэх;

3.3.4. Дансны баталгаат гарын үсгийн маяг, тамга, тэмдэг өөрчлөгдөж буй тохиолдолд холбогдох шийдвэр, итгэмжлэл, баримт бичгийг зохих журмын дагуу нэн даруй бүрдүүлж Банканд ирүүлэх;

3.3.5. Гэрээний 2.2 дахь хэсэгт заасан бүтээгдэхүүн, үйлчилгээг авахад шаардлагатай хуулийн шаардлага хангасан, хүчин төгөлдөр баримт бичгүүдийг Банканд бүрдүүлэн өгөх;

3.3.6. Карт, картын пин код, гар утас, цахим шуудан хаяг, цахим бүтээгдэхүүн, цахим үйлчилгээний нэвтрэх нэр, нэвтрэх болон гүйлгээний нууц үг, бусад баталгаажуулалтын хэлбэрийг бусдад дамжуулсан, задруулсан, алдсан, нуцлалын төхөөрөмжийг гээсэн, алдсан, нэвтрэх эрхийг зөвшөөрөлгүйгээр ашиглан аливаа эх үүсвэрээс хандах оролдлого хийсэн, хандсан, гүйлгээ хийх оролдлого гаргасныг мэдсэн тохиолдолд Банканд нэн даруй мэдэгдэж үйлчилгээний эрхээ түр хаалгах, мэдэгдээгүйн улмаас үүсэх хохирлыг Харилцагч бүрэн хариуцах;

3.3.7. Дансанд заавал байлгах үлдэгдлийг тогтмол байршуулах;

3.3.8. Дансны үлдэгдлийг улайлган ашигласан тохиолдолд БҮЕН болон ХШЕН-д заасны дагуу шимтгэл, хүү, торгууль болон улайлгасан үндсэн дүнг яаралтай төлж барагдуулах;

3.3.9. Харилцагч дараах үйлдлүүдэд гарсан хохирлыг бүрэн хариуцна. Үүнд:

3.3.9.а. Харилцагчийн хуулийн этгээдийн Улсын бүртгэлийн гэрчилгээ болон дүрэмд тусгагдсан нэр, хаяг болон бусад үндсэн мэдээллүүд болох холбоо барих утасны дугаар, баталгаат гарын үсэг, тамга тэмдэг, итгэмжлэлээр болон итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээдийн талаарх аливаа мэдээлэл өөрчлөгдөх бүрд нэн даруй Банканд мэдэгдэж, шинэчлүүлж байх, мэдэгдээгүйн улмаас үүдэн гарах Банк болон бусад харилцагч, өөрт учирсан аливаа хохирол;

3.3.9.б. Бүтээгдэхүүн, үйлчилгээний заавар, гарын авлагыг дагаж мөрдөх үүрэгтэй бөгөөд энэхүү үүргээ зөрчсөнөөс үүсэх аливаа хохирол;

3.3.9.в. Дансны гүйлгээний хуулгаа тогтмол шалгаж ямар нэгэн маргаантай бүюу хүлээн зөвшөөрөхгүй гүйлгээ хийгдсэн тохиолдолд гүйлгээ хийгдсэнээс хойш хуанлийн 30 хоногийн дотор Банканд мэдэгдэж шалгуулах, мэдэгдээгүйн улмаас бусад Банканд хандаж маргаан үүсгэх хугацаа өнгөрснөөс үүсэх хохирол;

3.3.9.г. Данс, эсхүл карт эзэмшигч, картаар үйлчлэгч байгууллага (цаашид "**КҮБ**" гэх), карт гаргагч, эсхүл картаар үйлчлэгч банкны аль нэг талын үүсгэсэн маргаантай гүйлгээг шалгах явцад Харилцагч нь Гэрээгээр хүлээсэн үүрэг болон бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэх заавар, зөвлөмжийг зөрчсөн болох нь нотлогдсон тохиолдолд гарсан хохирол, зардал;

3.3.9.д. Пин код, нууц үг болон бусад баталгаажуулалтын мэдээллийг мартсан, буруу оруулсны улмаас гүйлгээ хийж чадаагүй, гүйлгээ саатсанаас үүсэх аливаа хохирол.

3.3.10. Харилцагч нь Ти Ди Би Онлайн үйлчилгээг ашиглан өөрийн сонгосон багцаас хамааран Банкны үйлчилгээ авах боломжтой ба тухайн сонгосон Ти Ди Би Онлайн багцын үйлчилгээний талаарх (ямар эрхтэй, ямар үйлчилгээ авах боломжтой гэх мэт) мэдээллийг Банкны www.tdbm.mn цахим хуудасны бүтээгдэхүүний танилцуулга хэсгээс шинэчлэгдсэн байдлаар авах үүрэгтэй;

3.3.11. Хэрэв Харилцагч нь Монгол Улсад төлөөний газаргүй, татвар төлөгчөөр бүртгэгдээгүй гадаад улсад байнга оршин суугч байх тохиолдолд Гэрээний 7.3 дахь хэсэгт заасан Татвар төлөгчийн сертификатыг Банкны шаардсан хугацаанд ирүүлэх үүрэгтэй;

3.3.12. Харилцагчийн нэвтрэх эрхийг зөвшөөрөлгүйгээр ашиглан интернет, эсхүл мобайл хандалт хийснийг Харилцагч нь мэдсэн тохиолдолд энэ талаар нэн даруй Банканд мэдэгдэх үүрэгтэй;

3.3.13. Гэрээний 1.2.5 дахь заалтад заасан алдаатай гүйлгээ хийгдсэн тохиолдолд тухайн алдаатай гүйлгээг Банк Харилцагчийн данснаас үл маргах журмаар суутган авч, залруулахийг Харилцагч нь Банканд үүгээр зөвшөөрсөн. Ийнхүү Банк алдаатай гүйлгээг залруулсныг Харилцагчийн бичгээр өгсөн үүрэг буюу зөвшөөрлийн үндсэн дээр гүйцэтгэсэн гүйлгээ гэж үзнэ;

3.3.14. Харилцагч болон түүний гүйлгээг таньж мэдэх ажиллагааны хүрээнд Банкнаас шаардсан мэдээлэл, баримтыг түргэн шуурхай гаргаж өгнө.

3.3.15. Харилцагч банкны аливаа бүтээгдэхүүн үйлчилгээг залилан, луйвар, Монгол Улсын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуульд үл нийцэх байдлаар урвуулан ашиглахгүй байх;

3.3.16. **"Банкны дансаар ажилтнуудын цалин олгох үйлчилгээ"** авсан нөхцөлд дараах тусгай үүргийг хүлээнэ. Үүнд:

3.3.16.а. Харилцагч ямар нэг байдлаар ажилтнуудынхаа цалинг Банкны дансаар олгоохоргүй болсон тохиолдолд Банкнаас цалингийн зээл авсан ажилтны зээлийн төлбөрийг барагдуулж дуусах хүртэл хугацаанд тухайн ажилтны цалинг Банкны цалингийн дансанд шилжүүлэх үүрэгтэй.

3.3.16.б. Гэрээг аль нэг талын санаачилгаар цуцалсан тохиолдолд Ажилтны цалингийн зээл, зээлийн эрх, зээлийн эргэн төлөлтийн хугацаа дуусгавар болтол Харилцагч Банкан дахь цалингийн дансаар цалинг нь дамжуулах үүрэгтэй.

3.3.17. Хууль болон Гэрээгээр хүлээсэн бусад үүргийг зохих ёсоор биелүүлэх.

3.4. Харилцагч дараах эрх эдэлнэ. Үүнд:

3.4.1. Банкны ХШЕН болон БҮЕН, тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтүүдийг хүлээн зөвшөөрөхгүй бол нийтэд мэдээлсэн өдрөөс хойш хуанлийн 10 хоногийн дотор Банканд хандан санал, хүсэлт гаргах;

3.4.2. Хүсэлт гарган Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг шинээр авах, эрхээ сэргээлгэх болон хаалгах эрхтэй бөгөөд түр хаалгасан тохиолдолд хаалгасан хугацааны хураамж, шимтгэлийг Банк буцаан олгохгүй;

3.4.3. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Банкнаас шаардах;

3.4.4. Банктай байгуулсан Гэрээг цуцлах, эсхүл сонгосон үйлчилгээнээсээ татгалзах;

3.4.5. Банкны буруутай үйл ажиллагааны улмаас өөрт учирсан зардал, хохирлыг Банкаар төлүүлэх;

3.4.6. Бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой санал, хүсэлтийг Банканд гаргах;

3.4.7. Хууль болон Гэрээнд заасан бусад эрхийг эдлэх.

Дөрөв. Маргаан шийдвэрлэх

4.1. Төлбөр, тооцооны үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой Банк, Харилцагч болон КҮБ, эсхүл хүлээн авагчийн хооронд үүссэн маргаантай асуудлыг Харилцагч, КҮБ, эсхүл хүлээн авагчийн аль нэг талын хүсэлтээр 3 талын оролцоотойгоор хамтран зөвшилцөх журмаар шийдвэрлэнэ.

4.2. Банк, Монгол Улсын бусад банк болон гадаадын банкны сүлжээнд гарсан Картын төлбөр тооцоо, Ти Ди Би Онлайн үйлчилгээгээр хийгдсэн төлбөр тооцоотой холбоотой маргааныг Монголбанкны болон тус Банкны маргаан шийдвэрлэх заавар, журам, Олон Улсын төлбөрийн картын үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын (Виза, Мастеркарт, Юнионпэй г.м) маргаантай гүйлгээ шалгаж, шийдвэрлэх журам, "Банк болон Гэрээт банктай байгуулсан хамтран ажиллах гэрээ" болон бусад хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ. Гомдлыг шийдвэрлэх ерөнхий хугацаа хуанлийн 180 хоног байх бөгөөд тухайн маргааны төрлөөс шалтгаалан холбогдох журамд заасны дагуу тодорхойлогдоно.

4.3. Хэрэв Гэрээний 4.1-4.2 дахь хэсэгт заасан журмаар маргааныг шийдвэрлэж чадахгүй бол Монгол Улсын хуулийн дагуу Монгол Улсын Шүүхээр эцэслэн шийдвэрлүүлнэ.

Тав. Гэрээний хугацаа, түүнийг дуусгавар болох нөхцөл болон данс хаах тухай

5.1. Гэрээ нь Талуудын эрх бүхий этгээдүүд гарын үсэг зурж, тамга/тэмдгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох бөгөөд Гэрээг дараах үндэслэлээр цуцалж, дуусгавар болгох хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ. Үүнд:

5.1.1. Харилцагчийн хүсэлтийг үндэслэн Гэрээг цуцалж, дуусгавар болгоно;

5.1.2. Хэрвээ Харилцагч нь данс болон бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбогдох аливаа өр төлбөрийг бүрэн барагдуулаагүй бол тухайн төлбөрийг барагдуулж дуустал дансанд битүүмж тавьж, барагдуулж дуусан өдрөөс Гэрээг цуцалж, дуусгавар болгоно;

5.1.3. Харилцагч нь Гэрээгээр хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөн тохиолдолд Банк Гэрээг нэг талын санаачилгаар цуцалж, дуусгавар болгоно;

5.1.4. Харилцагч өөрийн дансыг төлбөр тооцооны бус зориулалтаар удаа дараа (2 болон түүнээс дээш) ашигласан (бусдын нэр дээр банкны баталгаа, тодорхойлолт гаргах үйлчилгээ эрхлэх, дансыг ашиглан бусдад хохирол учруулж болзошгүй буюу залилан луйврын шинжтэй үйлдэл гарах нөхцөл бүрдүүлэх үйл ажиллагаа, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх зорилгоор ашигласан) болон Банканд, гуравдагч этгээдэд хохирол учруулах үйлдлийг удаа дараа гаргасан тохиолдолд Банк Гэрээг дангаар цуцална;

5.1.5. Хуульд заасан бусад үндэслэлээр.

5.2. Гэрээний 5.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр Гэрээг дуусгавар болгосон тохиолдолд Банк нь Гэрээний 2.2 дахь хэсэгт заасан Харилцагчийн бүтээгдэхүүн, үйлчилгээ эзэмших эрхийг дуусгавар болгож, түүний дансыг хаана.

5.3. Гэрээний 5.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр Гэрээ дуусгавар болсон эсэхээс үл хамааран Гэрээ хүчин төгөлдөр байх хугацаанд үүссэн Талуудын эрх, үүрэг, хариуцлага нь бүрэн биелэгдэх хүртэл хүчин төгөлдөр хэвээр байна.

Зургаа. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах

6.1. Харилцагч БҮЕН, ХШЕН-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрсний үндэсн дээр Гэрээнд гарын үсэг зурж, тэмдэг (тамга) дарж (Түр данс нээлгэж буй тохиолдолд тэмдэг дарахгүй бөгөөд хуулийн этгээдийг байгуулсан тохиолдолд данс нээлгэсэн Банкны нэгжид хандан нөхөж тэмдэг дарна) баталгаажуулсан болно. Цаашид БҮЕН, ХШЕН-д орох нэмэлт, өөрчлөлтүүдийг Харилцагч нь Банкны www.tdbm.mn цахим хуудсаар орж танилцах бөгөөд Банк нь Харилцагчийн бүртгэлтэй цахим шуудангийн хаягаар дамжуулан мэдээлж болно.

6.2. Банк www.tdbm.mn цахим хуудсаараа дамжуулан БҮЕН, ХШЕН-д орсон нэмэлт, өөрчлөлтийн талаар хуанлийн 30 хоногийн өмнө нийтэд мэдээлэх ба ийнхүү мэдэгдэл хүргүүлснээс хойш 10 хоногийн дотор Харилцагчаас тухайн нэмэлт, өөрчлөлтийн талаар санал, хүсэлт ирүүлээгүй бол БҮЕН, ХШЕН-д орсон нэмэлт, өөрчлөлтийг Талууд харилцан хүлээн зөвшөөрсөн гэж үзэхээр тохиролцов.

6.3. БҮЕН болон ХШЕН-д нэмэлт, өөрчлөлт оруулахаас бусад тохиолдолд Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Нэмэлт,

өөрчлөлтийг бичгээр үйлдэж, Талуудын эрх бүхий этгээдүүд гарын үсэг зурж, тамга/тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.
6.4. Гэрээний 6.2 болон 6.3 дахь хэсгийн дагуу Гэрээнд орсон нэмэлт, өөрчлөлтүүд болон Хавсралтууд нь Гэрээний салшгүй нэг хэсэг байна.

Долоо. Хариуцлага

7.1. Харилцагч төлбөр тооцооны баримтыг хуурамчаар үйлдэх, залилан мэхлэх болон Гэрээгээр хүлээсэн бусад үүргийг зөрчих замаар Банканд хохирол учруулсан бол Харилцагч нь хохирлыг өөрийн дансан дахь мөнгөн хөрөнгөөс үл маргах журмаар төлнө.
7.2. Харилцагчийн дансны үлдэгдэл хүрэлцээгүй, төлбөр тооцооны баримтын бүрдүүлбэр дутуу, буруу болон хүлээн авагч банкны үйлчилгээний доголдол зэрэг шалтгааны улмаас харилцагчийн төлбөр саатсан бол үүсэх үр дагаврыг Банк хүлээхгүй.
7.3. Талуудын аль нэг нь Гэрээг зөрчсөнөөс нөгөө талдаа учирсан бодит хохирол, зардлыг Гэрээг зөрчсөн тал бүрэн хариуцна.
7.4. Гэрээний 5.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр Гэрээ нь дуусгавар болсон тохиолдолд Гэрээг хүчин төгөлдөр байх үед үүссэн төлбөр тооцооны эрх, үүрэг нь бүрэн биелэгдэж дуусах хүртэл хугацаанд Гэрээний зохицуулалт нь Талуудын хувьд хүчин төгөлдөр хэвээр мөрдөгдөнө.
7.5. Харилцагч нь өөрийн дансны дугаар, карт болон картын дугаар, хүчинтэй хугацаа, CVV код, пин код, интернет пин код болон соронзон туузны нууцлалын мэдээлэл, бусад бүтээгдэхүүн, үйлчилгээнд ашиглах харилцагчийн нэвтрэх нэр, нууц үг, гүйлгээний нууц үг, нэг удаагийн нууц дугаар, ТАН код болон нууцлалын мэдээллийг гуравдагч этгээдэд аливаа хэлбэрээр дамжуулахгүй, алдахгүй байх, хэрэв дамжуулсан болон алдсаны улмаас хохирол учирвал түүнийг бүрэн хариуцна.
7.6. Бүтээгдэхүүн, үйлчилгээг ашиглах явцад Харилцагч нь Гэрээнд заасан үүргийг биелүүлээгүйгээс Банканд болон гуравдагч этгээдэд санаатай болоод санамсаргүйгээр үүссэн аливаа хохирол, зардал, асуудлыг Харилцагч бүрэн хариуцна.
7.7. Харилцагч гүйлгээний мэдээллийг буруу оруулж гүйлгээ хийсний улмаас Харилцагчид үүссэн хохирлыг Банк хариуцахгүй.

Найм. Татвар

8.1. Харилцагчийн дансанд БҮЕН болон ХШЕН-ийн дагуу олгох хүүгийн орлого, түүнтэй адилтгах бусад орлого (цаашид "**Хүүгийн орлого**" гэх)-д ногдуулах албан татварыг Банк нь Монгол Улсын татварын хууль тогтоомжийн дагуу суутган ногдуулж, Монгол Улсын харьяалах татварын албанд шилжүүлнэ.
8.2. Хэрэв Харилцагч нь Монгол Улсад төлөөний газаргүй, татвар төлөгчөөр бүртгэгдээгүй гадаад улсад байнга оршин суугч байх тохиолдолд дараах журмын дагуу Хүүгийн орлогод татвар ногдуулна. Үүнд:
8.2.1. Харилцагчийн оршин суугаа Улсын Засгийн газар болон Монгол Улсын Засгийн газрын хооронд байгуулагдсан Давхар татварын хэлэлцээрт Хүүгийн орлогод Монгол Улс өөрийн хуулийн дагуу татвар ногдуулж болохоор заасан бол Банк нь Хүүгийн орлогод ногдуулах албан татварыг Давхар татварын хэлэлцээрт нийцүүлэн Монгол Улсын татварын хууль тогтоомжийн дагуу суутгавал зохих албан татварын дүнгээр суутгаж, Монгол Улсын харьяалах татварын албанд шилжүүлнэ;
8.2.2. Гэрээний 8.2.1 дэх заалтын дагуу Давхар татварын хэлэлцээрт Хүүгийн орлогод Монгол Улс өөрийн хуулийн дагуу татвар ногдуулахаар зааснаас бусад тохиолдолд Банк нь Хүүгийн орлогыг аливаа суутгал, хасалтгүйгээр бүтэн дүнгээр Харилцагчид олгоно.
8.3. Хүүгийн орлогод Гэрээний 8.2 дахь хэсэгт заасан журмын дагуу албан татвар ногдуулах тохиолдолд Харилцагч нь Банкны шаардсан хугацаанд татвар төлөгчөөр бүртгүүлсэн Улсын татварын албанаас гаргасан, тухайн татварын жилд хамаарах Татвар төлөгчийн сертификатыг Банканд ирүүлэх үүрэгтэй. Ийнхүү ирүүлээгүй бол Банк Хүүгийн орлогод Гэрээний 8.1 дэх хэсэгт заасан журмын дагуу албан татвар суутган ногдуулж, шилжүүлэх бөгөөд энэ тохиолдолд Банк аливаа хариуцлага хүлээхгүй болно.
8.4. Хэрэв Гэрээний 8.2 дахь хэсэгт заасны дагуу Харилцагчийн оршин суугаа улсын Засгийн газар болон Монгол Улсын Засгийн газар хооронд Давхар татварын хэлэлцээр байгуулагдаагүй тохиолдолд Хүүгийн орлогод ногдох албан татварыг Банк нь Гэрээний 8.1 дэх хэсэгт заасан журмын дагуу суутган ногдуулж, шилжүүлнэ.

Ес. Бусад зүйл

9.1. Гэрээг бичгээр байгуулж, хоёр хувь үйлдэн, Талууд тус бүр нэг хувийг хадгалсан нь хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.
9.2. Харилцагч төлбөр тооцоог гадаад валютаар гүйцэтгэхэд тухайн цаг хугацаанд Банкнаас зарласан арилжааны ханш, Олон Улсын сүлжээг ашиглах бол тухайн банкны хүү, шимтгэл, ханшийг хүлээн зөвшөөрч, гүйлгээ хийхийг Талууд үүгээр харилцан тохиролцов.
9.3. Харилцах данс нь зөвхөн төлбөр тооцооны зориулалттай бөгөөд дансыг аливаа хөрөнгө оруулалт болон өөр зориулалтаар ашиглахыг хориглоно.
9.4. Гэрээг шаардлагатай тохиолдолд англи, монгол 2 хэлээр үйлдэж, баталгаажуулж олгох боломжтой бөгөөд энэ тохиолдолд Монгол хэл дээр үйлдсэн гэрээ нь давуу хүчинтэй байна.
9.5. Гэрээ болон БҮЕН-ийн зохицуулалтууд хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Гэрээний зохицуулалт нь давуу хүчинтэй байхаар Талууд харилцан тохиролцов.

Гэрээний нөхцөлийг бүрэн уншиж танилцсаны үндсэн дээр Гэрээний нөхцөл, БҮЕН болон ХШЕН-ийг хүлээн зөвшөөрч ГЭРЭЭГ БАЙГУУЛСАН:

Банкийг төлөөлж:

.....

Харилцагчийг төлөөлж:

1-р гарын үсэг:

Нэр: .....

Албан тушаал: .....

Утас: .....

Цахим хаяг:.....

2-р гарын үсэг:

Нэр: .....

Албан тушаал: .....

Утас: .....

Цахим хаяг:.....

(Тамга/тэмдэг)